

ӨГҮҮЛЭЛ

Монгол-Оросын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийн зарим асуудлуудад хийсэн дүн шинжилгээ

Адъяагийн Нямдолжин 

Доктор (Ph.D)

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
nyamdoljin@mas.ac.mn

Хураангуй: Энэхүү өгүүлэлд зохиогч 1993 оны “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2000 оны “Улаанбаатарын тунхаглал”, 2006 оны Москвагийн тунхаглал, 2009 оны “Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”, 2019 оны “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ” зэрэг хоёр орны харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн хэмжээнд хүргэсэн, эрхзүйн үндэс суурь болсон баримт бичгүүд болоод бусад гэрээ хэлэлцээрүүдэд анализ хийх замаар хоёр орны харилцааны зарим тулгамдсан асуудлуудыг судлан шинжлэв.

Түлхүүр үг: гэрээ, хэлэлцээр, Монгол-Оросын харилцаа, Оросын үл хөдлөх хөрөнгө, их өр, төмөр зам

XX зууны хоёрдугаар хагаст ЗХУ-д өрнөсөн өөрчлөлт, шинэчлэлийн үйл явц гүнзгийрэн, улмаар ЗХУ задарч, Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл, Варшавын гэрээний байгууллага тарж, Берлиний хана нурж, “хүйтэн дайн” төгссөн зэрэг томоохон өөрчлөлт гарснаар олон улсын харилцаанд гүнзгий нөлөө үзүүлж, олон улсын байдал, дэлхийн дэг журам үндсээрээ өөрчлөгдсөн. Ийнхүү “хүйтэн дайн” дууссаны дараа Монгол, Орос хоёр улс

олон жилийн туршид хуримтлагдсан харилцааны сайн уламжлал, туршлага, өвөрмөц байдлыг хадгалахын сацуу түүхэн шинэ нөхцөл байдалд зохицсон эрх тэгш шударга, нээлттэй харилцах үзэл санаанд тулгуурлан, эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх, хуучин загварыг халах шаардлага зүй ёсоор тулгарсан юм.

ЗХУ-ын Засгийн газрын урилгаар БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбат, МАХН-ын Нарийн

© The Author(s), 2023

 <https://orcid.org/0000-0002-1672-8819>



<https://creativecommons.org/licenses/by/4.0/>

Received: 20 November, 2023

Accepted: 05 January, 2024

бичгийн дарга Г.Очирбат нар 1990 оны 5 дугаар сарын 14-нд Москва хотноо айлчлан ЗСБНХУ-ын удирдагч М.С.Горбачев, Коммунист намын ТХ-ны нарийн бичгийн дарга А.Н.Яковлев нартай уулзсан. Тус айлчлалын онцлог нь 1980-аад оны сүүл, 1990 оны эхэн үеэс эхэлсэн Монгол Улсын гадаад бодлогоо шинэчлэх, нийгмийг ардчилах үйл явцын хүрээнд хоёр улсын өмнө байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг эргэн харж хянах, холбогдох зүйл заалтуудыг өөрчлөх буюу нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл бүрмөсөн хасах, хоёр орон эдийн засгийн харилцаагаа төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцааны зарчимд суурилсан тогтолцоонд шилжүүлэн зохицуулах, хуримталсан сөрөг үр дагаврыг богино хугацаанд оновчтой засаж залруулах зэрэг хоёр улсын харилцаанд тулгарч буй асуудлуудыг даруй шийдвэрлэхэд оршиж байв.

ЗХУ задрахаас өмнө 1991 оны 2 дугаар сарын 12-нд ЗСБНХУ-ын Засгийн газрын урилгаар БНМАУ-ын Ерөнхий сайд Д.Бямбасүрэн ЗХУ-д ажлын айлчлал хийж, “БНМАУ, ЗСБНХУ-ын найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал” байгуулсан нь ЗХУ-д дээд түвшинд хэрэгжүүлсэн сүүлчийн дээд хэмжээний айлчлал байв. Гэвч тус тунхаглалын зүйл заалт хэрэгжиж амжилгүй ЗХУ задарсан боловч, тунхаглалд хоёр талын хамтын ажиллагааны асуудалд үзэл суртлын талаас хандах явдлаас харилцан татгалзахыг тунхагласны сацуу социалист хууль эрх зүйн тогтолцоо үйлчлэхээ больсноор хоёр орны харилцааны хууль эрхзүйн

үндэс суурийг шинэчлэх, хамтын ажиллагааны чиглэл, механизмуудыг тодорхойлох анхны хүчин чармайлт, оролдлого байсан гэж үзэж болно. Шилжилтийн үед социалист нийгэм, улс төрийн байгуулал, эдийн засгийн хэвшил, бааз суурь задран унасантай холбоотойгоор хоёр улс системийн гүнзгий хямралд нэг зэрэг нэрвэгдэж, худалдаа, эдийн засаг, соёл урлаг, шинжлэх ухаан зэрэг салбарын харилцаа холбоо алдагдаж, зогсонги байдалд орсон. 1991 оны 12 дугаар сард ЗХУ олон улсын харилцааны субъект байхаа больж түүний эрх, үүргийг ОХУ өвлөн авсан бол ардчиллын үзэл санааг тунхагласан 1992 оны шинэ үндсэн хуулиар БНМАУ-ыг цаашид Монгол Улс хэмээн нэрлэх болсон тэр цагаас Монгол, Зөвлөлтийн гэгдэж байсан харилцааны агуулга Монгол, Оросын харилцаа руу шилжсэн юм.

1990-ээд оны эхээр хоёр талаас хэрэгжүүлсэн дээд, өндөр түвшний харилцан айлчлал, уулзалтуудын үр дүнд байгуулсан гэрээ хэлэлцээрүүд нь Монгол, Зөвлөлтийн харилцаанд хуримтлагдсан асуудлуудыг даруй шийдэхэд чиглэж байлаа. Үүнээс нэн тэргүүнд тавигдаж байсан асуудлууд болох 1966 оноос хойш байрлаж байсан Зөвлөлтийн цэргийг Монгол Улсаас гаргах, хоёр орны харилцааны түүхийн “балархай” хуудсыг тодруулж, олон нийтийг үнэн зөв мэдээлэлтэй болгох, ЗХУ-д гарсан Монголын соёлын өвийг эргүүлэн авах, гадаад худалдааны саад тотгорыг арилгах, өрийн асуудлыг шийдэх зэргийг дурдаж болно.

Шинэ үеийн харилцааны эхлэлийг тавьсан 1991 оноос хойш Монгол, Оросын хооронд байгуулсан хоёр

орны харилцааг иж бүрэн стратегийн түншлэлийн хэмжээнд хүргэсэн, эрхзүйн үндэс суурь болсон таван баримт бичгийг талууд баталжээ. Эдгээрийг дурдвал:

“Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”.

1993 оны 1-р сарын 20-нд Москва хотноо Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат, ОХУ-ын Ерөнхийлөгч Б.Н.Ельцин нарын гарын үсэг зурсан “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” байгуулснаар Монгол, Оросын харилцааг ардчилал, шинэчлэлийн үзэл санааны хүрээнд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээний дагуу хөгжүүлэх, эрх зүйн суурь орчин бүрдсэн юм. Айлчлалын өмнөх жил 1992 оны есдүгээр сард Монгол дахь Зөвлөлтийн цэрэг гарч дууссан, хоёр орны улс төр, эдийн засгийн харилцаа бараг бүрэн зогссон байв. Шинэ харилцааг өмнөх шигээ үзэл сурталжсан, нэгнээсээ хараат байдалд оршдог “ах, дүүгийн” ивээлийн ёсоор бус олон улсын харилцааны түгээмэл зарчимд үндэслэн, эрх тэгш, бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг хүндэтгэх, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан хөгжүүлэхээр тохирчээ. Энэхүү гэрээгээр социалист интернационализмын тунхаглал болон цэргийн холбоотны үүргээс татгалзаж, ардчилсан зарчмыг баримтлахаа тунхагласан байна. Гэрээнд “аль нэг талын аюулгүй байдлын эрх ашигт заналхийлэл учирч болзошгүй гэж үзвэл түүний хүсэлтээр нэн даруй зөвлөлдөнө” хэмээн тусгажээ. Тус гэрээг хорин жилийн хугацаатай, мөн

тухай бүрд нь тав таван жилээр сунгах боломжтой байгуулсан. Харин 1994 оны Монгол Улс, БНХАУ-ын хоорондын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээг хугацаагүйгээр байгуулсан байдаг. Хэдий тийм боловч ЗХУ задарсны дараа ОХУ бусад хил залгаа орнуудтай бүгдтэй нь ийм төрлийн гэрээ байгуулаагүй байсан бөгөөд ямартаа ч хоёр орны олон улсын харилцааны нийтлэг ёс зүйг шингээсэн шинэ зарчмуудыг төлөвшүүлэх хамтын чин эрмэлзэл шингэсэн гэрээ байсан хэмээн дүгнэх бүрэн боломжтой юм.

“Улаанбаатарын тунхаглал”.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабандийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин 2000 оны 11-р сарын 13-14-ны өдөр Монгол Улсад төрийн айлчлал хийв. Нийгмийн шинэ тогтолцоонд шилжсэнээр Монголд ч, Орост ч шилжилтийн үеийн зорилтуудыг шийдвэрлэх төвөгтэй нөхцөл байдал бий болж, үүнээс үүдэн хоёр талын харилцааны ерөнхий далайц хумигдаж, худалдаа, эдийн засгийн болон соёл, хүмүүнлэгийн зэрэг зарим салбарын хамтын ажиллагаа тодорхой хугацаанд зогсонги байдалд орсон юм. “Улаанбаатарын тунхаглал” нь ийнхүү хоёр орны харилцааны зогсонги үеийн дараах эрхзүйн болон улс төр, дипломатын тогтвортой үндэс суурийг хангасан баримт бичиг болсон. Тус тунхаглалын нэг гол үзэл санаа нь ОХУ зөвхөн Өрнөд рүү чиглэсэн бодлогоосоо татгалзан Ази руу чиглэсэн бодлого хэрэгжүүлэхийг тус бүс нутагт хамрагдах Монгол Улстай эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэн хөгжүүлэх эрмэлзлээр илэрхийлэгдэж байна. Тухайлбал, Ази

Номхон далайн бүс нутагт бий болсон албан ёсны болон албан ёсны бус ярианы хэлэлцээний бүтцүүдийг бүрэн дэмжиж, АНД-н эдийн засгийн хамтын ажиллагааны (АПЕК) гишүүн болох гэсэн Монгол Улсын эрмэлзлийг ОХУ дэмжиж байгаагаа илэрхийлэв.

Москвагийн тунхаглал.

ОХУ-ын ерөнхийлөгч В.В.Путины урилгаар Монгол Улсын ерөнхийлөгч Н.Энхбаяр 2006 оны 12-р сарын 4-9-ний өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Хоёр улсын харилцааг стратегийн түншлэлийн хэмжээнд хөгжүүлэх, цар хүрээг нь тууштай нэмэгдүүлж, агуулгыг нь баяжуулж, үр ашгийг нь дээшлүүлэх замаар илүү өндөр, чанарын шинэ шатанд гаргах тохиролцоонд хүрч, “Москвагийн тунхаглал” гаргаж, ОХУ Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцаа тогтоосон анхны улс болсон. Энэхүү тохиролцооны агуулга нь хоёр оронд бүрэлдсэн нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинэ боломж, чадавхыг ашиглан харилцааны цар хүрээ, үр ашгийг чанарын шинэ шатанд гаргах, найрсаг уур амьсгалыг хадгалан бататгахад чиглэж байв.

Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведев 2009 оны 8-р сарын 25-26-ны өдрүүдэд Монгол Улсад төрийн айлчлал хийж, “Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал” гаргав. Стратегийн түншлэлийг хөгжүүлэх зорилттой уялдуулан хоёр талын харилцааны гэрээ, хэлэлцээрүүдийг данслах ажлыг сэргээх, энэ хүрээнд худалдаа-эдийн

засгийн хамтын ажиллагааны тухай засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийг шинэчлэх асуудлыг авч үзэхээр тохиролцов. Тээврийн дэд бүтэц, ураны болон ашигт малтмалын бусад орд газрыг ашиглах салбарын хамтарсан төслүүдийг зохих ёсоор урагшлуулах шаардлагатай гэж үзэв. Эдгээр тохиролцоог хэрэгжүүлэх ажилд аль болохоор түргэн орох үүднээс шаардлагатай алхам хийхэд бэлэн байгаагаа талууд илэрхийлсэн. “Дорнод уран” хамтарсан компани байгуулах тухай засгийн газар хоорондын хэлэлцээрт гарын үсэг зурж, энэхүү хэлэлцээрийг Монгол-Оросын стратегийн түншлэлийг бэхжүүлэх чухал хэсгийн нэг гэж үзсэн байна.

Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ.

2019 оны 9-р сарын 3-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулгын урилгаар ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын үеэр хоёр орны хооронд “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ”-г хугацаагүйгээр байгуулснаар хоёр улсын харилцааны хүрч болох хамгийн дээд түвшний харилцаанд хүрэв. Айлчлалын үеэр хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх Засгийн газар, яамд хоорондын нийт 10 баримт бичигт гарын үсэг зурсны дийлэнх нь эдийн засгийн харилцааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсний зэрэгцээ уламжлалаа сэргээж уул уурхайн салбарт хайгуулын чиглэлээр хамтран ажиллахаар болов.

Өнгөрсөн гуч гаруй жилийн хугацаанд хоёр орны харилцаа, хамтын

ажиллагаандтулгамдажбайсантомоохон асуудлуудыг шийдвэрлэхэд хоёр талаас хэрэгжүүлсэн өндөр, дээд түвшний харилцан айлчлал, уулзалтуудын үр дүнд хоёр орны харилцаа Иж бүрэн стратегийн түншлэлийн түвшинд

хүрэв. Энэ хугацаанд хоёр орны төр, парламент, засгийн газрын удирдлага, Гадаад хэргийн болон бусад яамдын сайд зэрэг өндөр, дээд түвшний төлөөлөгчдийн айлчлал хоёр урсгалтай болж тогтмолжсон байна.

Гэрээ хэлэлцээрүүд дэх улс төрийн харилцааны зарим асуудлуудыг шинжих нь

1991 оны “Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал”, 1993 оны “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд “Монгол Ардын Засгийн газар, ЗСБНХОУ-ын Засгийн газрын хооронд найрамдалт харилцаа тогтоох тухай 1921 оны 11-р сарын 5-ны өдрийн Хэлэлцээр сайн хөршийн харилцааг хөгжүүлэх, БНМАУ-ын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх үйлсэд түүхэн үүрэг гүйцэтгэсэн”-ийг² тэмдэглэсэн явдал Монгол, Оросын харилцааны 70 жилийн түүхэн харилцааны онцлогийг тодотгохын сацуу тус гэрээг хоёр орны харилцааг анх эхэлсэн тэр гарааны цэгтэй холбох 1921 оны хэлэлцээрийг дурдсан нь Монголын хамгаалагчийн үүргээ Орос орхиогүй юм байна гэсэн санааг агуулж байв. XX зууны эхэнд Орост Октябрийн хувьсгал гарсны улмаас Богд хаант Монгол Улсын Засгийн газар 1919 онд Хятадыг түших шийдвэр гаргамагц Хятадын цэрэг Хүрээнд нэвтэрч, Монголын тусгаар тогтнолд аюул тулгарч байв. 1921 онд Ардын хувьсгал ялсны дараа ч Орос,

Хятад, Япон улсуудын геополитикийн бодлогын улмаас Монгол Улсын тусгаар тогтнолын асуудал хүнд бэрх цаг хугацааг туулахад хүрч байлаа³. Нэг талаас, Оросын байр суурь, бодлого нь олон улсын тавцан дээр Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн, нөгөө талаас Монгол Улс аюулгүй байдлаа “буфер” улсын байдлаар хангаж ирсэн. Энэ ч үүднээс XX зууны тэргүүн хагаст Оросын хувьд Монголын буферын үүргийг хэвээр байлгах, Монголын хувьд тусгаар тогтнолоо олон улсын хэмжээнд зөвшөөрүүлэн баталгаажуулах хүчин чармайлтаас үүдэн Монгол, Орос хоёр орны ашиг сонирхол нэг цэгт огтлолцож байв. Ийнхүү Монгол Улс XX зууны турш тусгаар тогтнолын асуудалтай холбоотойгоор буфер улсын үүргээ төдийлөн үнэлүүлж чадаагүй ба өнөөдөр ч Оросын байр суурь түүхэн давтамжтай хоёрдмол шинжтэй байна.

Харин 2009 оны “Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”-д “эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө

² БНМАУ, ЗСБНХОУ-ын Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. , Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. 1991-2004 он. УБ. 2006. 5, 24-р тал.

³ А.Нямдолжин. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. УБ. 2022. 144-р тал.

хамтын тэмцэл, энхийн бүтээн байгуулалтын явцад улам багжин бэхэжсэн хоёр орон, ард түмний хоорондын уламжлалт найрсаг харилцаа холбоо онцгой шинж чанартайг тэмдэглэн, Монгол Улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө 1921 онд мөр зэрэгцэн тэмцэж, 1939 онд түүнийг Халхын голд хамгаалсан, дэлхийн хоёрдугаар дайны жилүүдэд фашизмын эсрэг хамтран тулалдаж явсныг⁴ онцлон тэмдэглэсэн. Ийнхүү 2009 оны ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевын Монгол Улсад хийсэн айлчлалаас эхлэн Халхын голын байлдааны ялалтын ойн баярыг тэмдэглэх явдал ОХУ-ын Ерөнхийлөгчийн айлчлалын салшгүй нэгхэсэгболсон юм. Тухайлбал, 2009 оны ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведевын Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр Халхын голын байлдааны ялалтын 70 жилийн ойг тэмдэглэсэн бол 2014 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын голын байлдааны ялалтын 75 жилийн ойг, 2019 онд ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойг тэмдэглэсэнээс харахад тэрхүү дайнд Орос Улс гол үүрэгтэй оролцож, Монголчуудыг хамгаалан, Монгол Улсын эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататгахад чухал үүрэг гүйцэтгэсэн гэдгээ давхар сануулахын зэрэгцээ цаашид ч хамтран ажиллахад саад болох зүйлгүй бөгөөд цаг хугацааны сорилтоор шалгагдсан хоёр орны хоорондын уламжлалт харилцаа хэвээр хадгалагдан үлдсэн

гэдгийг харуулсан айлчлалууд байсан хэмээн дүгнэж болохоор байна. Халх голын байлдааны ялалтын ойн арга хэмжээ нь хоёр орны улс төрийн харилцааг тодорхойлох нэг чухал үйл явдал болох нь эндээс харагдаж байна.

1993 оны “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд “талууд бие биеийн эсрэг чиглэсэн цэрэг-улс төрийн аливаа эвсэлд оролцохгүй бөгөөд нөгөө талын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолын эрх ашигт харшилсан ямар нэг гэрээ, хэлэлцээрийг гуравдагч орнуудтай байгуулахгүй байх, гадаадын цэрэг, цөмийн үй олноор хөнөөх бусад төрлийн зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх, нутаг дэвсгэрээрээ дамжуулан өнгөрүүлэхгүй байхад чиглэсэн Монгол Улсын бодлогыг ОХУ хүндэтгэнэ⁵ гэж заажээ. 2019 оны “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээ”-нд дээрх заалт дээр “нөгөө талын эсрэг чиглэсэн аливаа үйлдэлд оролцох, эсхүл ийм төрлийн үйлдлийг дэмжихээс түдгэлзэнэ. Аль ч тал өөрийн нутаг дэвсгэрээ нөгөө талын эсрэг түрэмгийлэл буюу аливаа хүчирхийлэл үйлдэх зорилгоор гуравдагч улсад ашиглуулахгүй” гэсэн заалт нэмж орсон нь анхаарал татаж байна. Энэ нь өнгөрсөн үеийн хоёр орны туршлагаас үүдэн Монгол Улсын хувьд чухал заалт юм. Монгол Улс түүхэндээ хоёр хөршийнхөө нэгэнтэй нь эвсэж, өөрийн газар нутгийг нөгөө хөршийн эсрэг хамгийн ойроос цохилт өгөх чадавхыг бүрдүүлсэн байдаг. Чингэхдээ 1960-

⁴ Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 76-р тал.

⁵ Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. , Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. 1991-2004 он. УБ. 2006. 25, 26-р тал.

аад онд буюу 60 гаруй жилийн өмнө ЗХУ, БНХАУ-ын харилцаа муудахад Монголын удирдлага Москвагийн талд зогссоноор Зөвлөлтийн цэрэг Монголын нутаг дэвсгэрт бараг 30 жил байрласан юм⁶. Тэр үед дайн гарсан бол дайны тэргүүн шугам болж, хамгийн түрүүнд хохирогч болох аюултай байв. Хятадын боломжит түрэмгийллийн эсрэг чиглэсэн 1966 оны хоёр орны хоорондын “Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ”-гээр гаднын халдлагад өртсөн тохиолдолд ЗХУ БНМАУ-ыг хамгаалах, харилцан бие биедээ туслах үүрэг хүлээсэн байдаг.

2000 оны “Улаанбаатарын тунхаглал”-д “Оросын тал олон улсын өргөн хамтын ажиллагааны нээлттэй байгууллага болох Шанхайн чуулга уулзалтын зорилго, зорилт, үйл ажиллагааны тухай Монголын талд мэдээлсэн” ба 2006 оны “Москвагийн тунхаглал”-д “Монгол Улс, Орос Улс, Төв Азийн улс орнуудын сайн хөршийн харилцаа, олон талт түншлэлийг хөгжүүлэхэд Шанхайн хамтын ажиллагааны байгууллага чухал үүрэг гүйцэтгэж байгааг тэмдэглэн “Шанхайн хамтын ажиллагааны байгууллагын таван жилийн ойн тунхаглал”-ын үзэл санааны дагуу эрчим хүч, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, хөдөө аж ахуй зэрэг тэргүүлэх салбарт ШХАБ-ын хүрээнд түншлэлээ идэвхжүүлэхийг

сонирхож байгаагаа илэрхийлсэн байна. 2009 оны 5-р сарын 13-нд Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын урилгаар ОХУ-ын Засгийн газрын дарга В.В.Путин Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр Монголын тал ШХАБ-ын хүрээнд дэх эдийн засгийн, түүний дотор эрчим хүчний төслүүдэд оролцох сонирхолтой байгаагаа илэрхийлсэн⁷. 2009 оны “Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”-д ШХАБ-ын хүрээнд харилцан ажиллахын чухлыг тэмдэглээд тус байгууллагын хүрээнд эрчим хүч, тээвэр болон бусад тэргүүлэх салбарт хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар гишүүн орнууд болон ажиглагч улсуудын хамтын ажиллагааны механизмыг бэхжүүлэх асуудлаар цаашид мэдээлэл солилцох, хоёр болон олон талын зөвлөлдөөн хийж байхаар тохиролцжээ⁸. Үүнээс харахад 2004 онд Монгол зэрэг оронд зориулж тусгайлан ажиглагчийн статус бий болгосон бөгөөд “ШХАБ-ын ажиглагчийн статусын тухай байдал”⁹-ыг баталсан хийгээд Монгол Улс ШХАБ-д ойртуулах аядуу шахалтыг эсэргүүцэж чадалгүй анхны ажиглагч орон болсон. Улмаар Оросын талаас тус байгууллагад гишүүнээр элсэн орохыг дэмжинэ гэдгээ байнга илэрхийлж байдаг бөгөөд өндөр дээд хэмжээний уулзалт бүрээр энэ тухай сануулсаар байдаг. Монгол Улсын аюулгүй байдлын баталгаа нь

⁶ А.Нямдолжин. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. УБ. 2022. 144-р тал.

⁷ ОХУ-ын Засгийн газрын дарга В.В.Путины Монгол Улсад ажлын айлчлал хийсэн тухай хэвлэлийн хамтарсан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 71-р тал.

⁸ Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 82-р тал.

⁹ Положение о статусе наблюдателя при Шанхайской организации сотрудничества. 16 июня 2004. <http://www.kremlin.ru/supplement/3917>

хоёр хөрштэйгөө сайн харилцаатай байх явдал тул ШХАБ-д элсэх гэхээсээ илүү ажиглагчийн байр сууриа цаашид ч хадгалсаар байх нь өнөөгийн олон улсын нөхцөл байдал төвөгтэй байгаа энэ үед “гуравдагч” орнуудын Монгол дахь ашиг сонирхолд үл нөлөөлөх чухал байр суурь болох нь дамжиггүй. Энэ нь Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалд тусгасан хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харилцаж, аль нэгийг нь

өрөөсгөлөөр дагахгүй байх, “гуравдагч хөрш” орнуудтай харилцах харилцаагаа зогсонги байдалд оруулахаас сэргийлэх, нөгөөтээгүүр терроризм, экстремизм, сепаратизмын үзлийн эсрэг тэмцлээ зарласан энэ байгууллагад элссэнээр шууд Монгол Улсын эрх ашгийг хөнддөггүй, үндэстний болоод шашны асуудалд оролцох нь эргээд Монголд шинэ аюулын эх үүсвэрийг бий болгож болзошгүй юм.

Монголоос Оросын цэргийг гаргах асуудал болон Монголын нутаг дэвсгэр дээрх Оросын үл хөдлөх хөрөнгийн асуудал

БНМАУ-ын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийг гаргаж, БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгох асуудал бүр 1980-аад оны эхэн үеэс өндөр дээд түвшинд яригдаж эхэлсэн бөгөөд 1986 оны 7-р сарын 28-нд М.С.Горбачёв Владивосток хотноо хэлсэн үгэндээ: “Монголын нутаг дэвсгэрээс Зөвлөлтийн цэргийн үлэмж хэсгийг гаргах тухай асуудлыг Монголын удирдагч нартай зөвшилцөж байна” хэмээн мэдэгдсэн. 1987 оны 4-р сарын 11-ны “Известия” сонинд: “БНМАУ-ын Засгийн газартай тохиролцсоны дагуу Монголоос мотобуудлагын дивиз, хэд хэдэн анги нэгтгэлийг гаргаж эхлэх тухай ЗХУ-ын Батлан хамгаалах яамны шийдвэрийг мэдэгдсэний дагуу 1987 оны 4-р сараас “БНМАУ-д түр хугацаагаар байрлуулсан Зөвлөлтийн цэрэг”-ийн бүрэлдэхүүнд байсан буудлагын бүрэн моторжуулсан нэг дивиз болон хэд хэдэн тусгай ангийг

эргүүлэн татсан. 1990 оны 3-р сарын 2-ны “Монголоос цэргээ гаргах тухай ЗХУ-БНМАУ-ын хоорондын хэлэлцээр” - ээр Зөвлөлтийн цэргийг Монголоос бүрэн гаргах асуудлаар зарчмын тохиролцоонд хүрч, цаашлаад БНХАУ-тай харилцаагаа хэвийн болгоход 1990 оны 4-р сарын 24-ны “Зэвсэгт хүчнийг харилцан цөөлөх, Зөвлөлт, Хятадын хилийн бүс нутагт цэргийн салбарт итгэх итгэлийг бэхжүүлэх үндсэн чиглэлийн тухай ЗХУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”¹⁰ чухал ач холбогдолтой алхам болсныг дурдах нь зүйтэй.

Эхний шатанд 1989, 1990 онуудад цэргийн 75 хувь, өөрөөр хэлбэл 50.000 хүнийг, 2-р шатанд 1990 оны 5-р сарын 15-наас 8-р сарын 1-нийг хүртэл нийт 26.800 бие бүрэлдэхүүн бүхий байлдааны гурван ангийг 436 танк, 375 их буу, 400 хуягт тээвэрлэгчийн хамт Сайншанд, Чойр, Багануур, Дорнод

¹⁰ Соглашение между Правительством Союза Советских Социалистических Республик и Правительством Китайской Народной Республики о руководящих принципах взаимного сокращения вооруженных сил и укрепления доверия в военной области в районе советско-китайской границы. Москва. 24.04.1990. <https://base.garant.ru/2570276/>

орчмын нутгуудаас татан гаргажээ¹¹. Ийнхүү 1989-1992 онд Орос Улс Монголоос цэргээ бүрэн гаргасан нь Монгол, Орос, Хятад гурван улсын хоорондын хурцадмал байдлыг намжааж, Монгол-Оросын харилцаанд Хятадын зүгээс шууд цэргийн аюул заналхийлэл учруулж байсан хүчин зүйлийн нөлөөг бууруулсан. Алс Дорнодод явуулж байсан Оросын гадаад бодлого дахь Монголын стратегийн ач холбогдол буурсан явдал хоёр орны харилцааны эрчим тодорхой хугацаанд сулрах нэг хүчин зүйл болсон гэж үзэж болно.

Монголын нутаг дэвсгэрээс Оросын цэрэг гарсантай холбогдуулан өнөөг хүртэл яригдсаар байгаа нэг асуудал бол Монголын нутаг дахь Оросын өмчийн асуудал юм. 1993 оны 4-р сарын 27-ны “Монголын нутаг дэвсгэрээс Оросын цэрэг болон Зөвлөлтийн мэргэжилтнүүд Монголын нутгаас гарсантай холбогдуулан өмч болон санхүүгийн асуудлыг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”¹² болон тус хэлэлцээрийн протоколын хавсралтад жагсаасан хөрөнгөө шийдэх асуудал яригдах болсон. Уг асуудлыг зохицуулахаар Монгол-Оросын хамтарсан ажлын хэсгийг Монгол Улсын Засгийн газар ОХУ-ын Засгийн газар Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр 2003 оны 6-р сард ОХУ-д албан ёсоор айлчилсан айлчлалын дүнгийн тухай хамтарсан албан мэдээнд

“Монгол Улсад байнга оршин сууж байгаа ОХУ-ын иргэдэд эзэмшиж буй орон сууцыг нь үнэ төлбөргүй хувьчлах тухай Монголын талын гаргасан шийдвэрийг мэдэгдсэн бол Оросын тал Монголын нутаг дахь ОХУ-ын өмчийн орон сууцны зарим байшинг Монголын талд үнэ төлбөргүйгээр шилжүүлж өгөхөд бэлэн байгаагаа мэдэгдсэн”.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 2003 оны 10-р хуралдаанаар Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгө, ОХУ дахь Монгол Улсын үл хөдлөх хөрөнгийн асуудлаар хоёр талын ажлын хэсэг байгуулсан байна. Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр 2008 оны 4-р сарын 10-13-ны өдрүүдэд ОХУ-д айлчлах үеэр гарсан албан мэдээнд өмнөх тохиролцоог хэрэгжүүлэх үүднээс “Орос Улс Монгол Улсад Улаанбаатар хотын гурван дүүрэгт байгаа орон сууцны нийт долоон байрыг үнэ төлбөргүй шилжүүлэн өгснөө мэдэгдэж, Улаанбаатар, Дархан хотуудад байгаа орон сууцны найман байрыг шилжүүлэн өгөх ажлыг богино хугацаанд дуусгахаар” тохиролцсон байна. Түүний дараа 2009 онд хоёр улсын ерөнхийлөгч нар хэлэлцээ хийж, “Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал” -д дээрх найман байрыг Монголын талд шилжүүлэх шийдвэрийг дахин нотолсон¹³. 2016 оны 4-р сарын 16-ны Монгол Улс, ОХУ-ын хооронд

¹¹ Удо Баркман. Орчин цагийн Монголын тухай өгүүлүүд. УБ.2008. 25-р тал.

¹² Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Оросын цэргийн байрлах нь дуусгавар болж гарахтай холбогдсон эд хөрөнгийн болон санхүүгийн асуудлыг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. <https://irkutsk.consul.mn/post/1346>

¹³ Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 78-р тал

“Стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-г “Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудал болон харилцан тохиролцох жагсаалтын дагуу газар эзэмших эрхийг ЗСБНХУ-аас ОХУ-д шилжүүлэн бүртгүүлэх ажлыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ” хэмээн тусгаж, хоёр орны Засгийн газрууд хоорондын 1971 оны протокол, 1979 оны хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулна¹⁴ гэжээ.

2019 оны 12 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ОХУ-д хийсэн айлчлалын үр дүнд хоёр улсын хооронд 20 гаруй жил яригдсан Монгол дахь ОХУ-ын орон сууцны байрны асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн байдаг. Гэвч тус айлчлалыг угтаж хэд хэдэн асуудлыг шийдвэрлэсний дотор Монгол дахь Оросын газар болоод үл хөдлөх хөрөнгийн асуудал байв. Тухайлбал, “БНМАУ-д тусламж үзүүлж буй Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны протокол” болон “ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд

дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны хэлэлцээр” гэсэн хоёр баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах тухай ОХУ-ын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 1-р сарын 22-ны хэлэлцээр хэмээн нэрлэсэн “N538н/1да” дугаар нотод¹⁵ дурдсанаар “Монголын тал Улаанбаатар болон Дархан хот дахь газар, тэдгээрт байрлаж буй ОХУ-ын өмчийн үл хөдлөх хөрөнгийн объекттой холбоотой эрхийг ЗСБНХУ-ын нэр дээрх бүртгэлээс ОХУ-ын нэр дээр шинэчлэн бүртгэнэ. Монголын тал эдгээр газрыг Оросын талд холбогдох ашиглалтын гэрээнд заасан нөхцөлийн дагуу 60 жилээр ашиглуулах, ингэхдээ цаашид ашиглалтын хугацааг 40 жилээр аливаа нөхцөлгүйгээр сунгах эрхтэйгээр шилжүүлж өгнө. Холбогдох эдэлбэр газрыг цаашид ашиглах нөхцөлийг Талууд 100 жилийн хугацаа дуусахаас хоёр жилийн өмнө хэлэлцээ хийх замаар хэлэлцэн тохиролцоно” гэжээ. Чингэхдээ 28 үл хөдлөх хөрөнгө буюу эдэлбэр газрын жагсаалтыг тус хэлэлцээрт хавсралтаар ирүүлсэн байна. 2019 оны 9-р сарын 12-нд дээрх хоёр баримт бичигт нэмэлт, өөрчлөлт

¹⁴ Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 166-р тал

¹⁵ “БНМАУ-д тусламж үзүүлж буй Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар, ЗСБНХУ -ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн протокол” болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ -ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр”-г нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг. Төрийн мэдээлэл. 2019.10.7. №38 /1091/, 1411-р тал.

оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын ноот бичгийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталж, Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газрын хооронд ноот бичиг солилцох замаар байгуулсан хэлэлцээрийн хавсралтад дурдсан жагсаалтын дагуу Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 2 дугаар хороололд байрлах 17 дугаар байрны 24 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 15 дугаар хороололд байрлах 1, 7, 11, 12, 13 дугаар байр, Дархан-Уул аймгийн Дархан сумын 22 дугаар хороололд байрлах 3, 4 дүгээр байр зэрэг 14 үл хөдлөх хөрөнгийг Монгол Улсын өмчид шилжүүлэн өгсөн байна. Үлдсэн үл хөдлөх хөрөнгө болон газрыг дээрх хоёр баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах замаар ОХУ-ын улсын мэдэлд үлдээхээр болжээ.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Москва хотноо 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдөр хийсэн хэлэлцээний үеэр гаргасан “Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан Тунхаглал”¹⁶-д “Оросын Холбооны Улсын үл хөдлөх хөрөнгийн өмчийн эрхийг хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу бүртгэх, Монгол Улсын нутаг

дэвсгэрт газар ашиглах ОХУ-ын эрхийг шинэчлэн бүртгэх үйл явцыг аль болох хурдан хугацаанд дуусгахын тулд үргэлжлүүлэн нягт хамтран ажиллах болно” хэмээн мэдэгдсэн байна.

Түүнчлэн хоёр талын яриа хэлэлцээр болоод Оросын талаас удаа дараа Монгол Улсын шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлэхээр дэвшүүлж буй үл хөдлөх хөрөнгийн асуудалд Санкт-Петербург төв, Орос 3-р сургууль болон бусад газруудын асуудал ч гарч ирэх болсон байна. Тухайлбал, Оросын Холбооны Улсын Гадаад хэргийн яамны 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11381н/1да дугаартай эсэргүүцлийн ноот бичгийг Монголын талд ирүүлснээр Санкт-Петербург төв (хуучнаар Ленин клуб), Орос 3-р сургууль, “Төмөр замын бүх чиглэлийн дагуух нийтдээ 120 метр өргөн зурвас газар ба харин станцууд дээр ургаашаа 2000 метр хүртэл, өргөнөөрөө 300 метр газрыг нийгэмлэгийн ашиглалтад хугацаагүйгээр шилжүүлэн хэрэглүүлнэ” хэмээн 1949 оны хэлэлцээрийн 5-р зүйлийн б-д тусгасан заалтуудыг үндэслэн Оросын талаас 2023 оны 04 сарын 03 өдрийн Дээд шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан¹⁷. 2023 оны 10-р сарын 24-нд хуралдсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 25-р хуралдаанд Монгол Улс дахь ОХУ-ын маргаантай өмчийн асуудлаар II шатны ажил

¹⁶ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан Тунхаглал. <https://mfa.gov.mn/65949>

¹⁷ Улсын Дээд шүүхийн тогтоол. Дугаар 001/ХТ2023/0024. 2023 оын 04 сарын 03 өдөр. https://shuukh.mn/single_case/3045?daterange=2023/01/01%20-%202023/06/01%20&id=3&court_cat=3&bb=1

дууссаныг тайлагнасан байна. ОХУ-ын өмчийн болон газрын маргааны асуудал хоёр орны харилцаанд нөлөөлөхөөр асуудал биш боловч ЗХУ-ын үеийн хоёр талын зарим гэрээ, хэлэлцээр өнөө хир хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа нь зарим асуудлууд эцэслэн шийдвэрлэгдэхэд саад учруулж байна.

Гэрээ хэлэлцээрүүд дэх эдийн засгийн харилцааны зарим асуудлуудыг шинжих нь

Их өрийн асуудал.

АИХ-ын Тэргүүлэгчдийн дарга П.Очирбатын 1990 оны 5 дугаар сарын 14-нд Москва хотод хийсэн ажлын айлчлалын үеэр ЗСБНХУ-ын Ерөнхийлөгч М.С.Горбачёвтай хийсэн хэлэлцээгээр өрийн асуудлыг Засгийн газрын түвшинд хэлэлцэхээр харилцан тохиролцжээ. 1990 оны 7-р сард болсон Монгол-Зөвлөлтийн Засгийн газрын Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны тэгш эрхт комиссын 38-р хуралдааны үеэр өрийн асуудлаар явуулсан яриа хэлцэл Монголын талд хүлээн зөвшөөрөхүйц шийдэлд хүрч чадаагүй. 1990 оны 7-р сарын 29-нд Сайд нарын Зөвлөлийн 1-р орлогч дарга Д.Бямбасүрэн өрийн асуудлын тухайд олон улсын эдийн засаг, санхүүгийн байгууллагуудаас тусламж авч болох юм гэж мэдэгджээ. Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн 1992 оны 3 дугаар сард Москвад хийсэн ажлын айлчлалын үеэр ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга А.Н.Шохинтай хийсэн хэлэлцээ, түүний үр дүнгээр гаргасан Протоколд: “Хуучин ЗСБНХУ-д төлөх Монголын өр үүссэн асуудлыг хэрхэн үзэж байгаагаар

монголын тал тайлбарлаж ярив. Янз бүрийн арга хэлбэрээр түүний дотор хамтарсан үйлдвэрүүдийн дүрмийн санд оросын тал оруулах хувийг өрийн хэсгээр тооцох зэргийг оролцуулан өрийг зохицуулах асуудлыг хамтран судалж үзэхийг Монгол, Оросын холбогдох байгууллагад үүрэг болгохоор Талууд тохиролцов”¹⁸ гэсэн байна. Тус протоколд тусгаснаар Монгол, Оросын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын хуралдааныг Улаанбаатар, Москва хотуудад эхлүүлэн жил тутам хийж байхаар тохиролцсон 1992 оны 5-р сарын 31-нд хуралдсан комиссын анхдугаар хуралдааны протоколд “1991-1995 онд ногдох үндсэн өрийн төлбөрийг 2000 оноос цаашиг хугацаанд хүү ногдуулахгүйгээр хойшлуулах талаар урьд тохирсон тохиролцоог талууд батлав”¹⁹ гэснээс харахад хүүгийн өсөлт энэ үе хүртэл үргэлжилсээр байжээ.

Тус комиссын хуралдааны протоколд өрийн асуудлыг шийдэх боломжийг дэлгэрэнгүй авч үзсэний дотор: өрийн хөрөнгийг ЗХУ-ын тусламжтайгаар барьж байгуулсан Монголын үйлдвэрүүдэд дахин

¹⁸ Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн ОХУ-д хийсэн ажлын айлчлалын тухай протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 10-р тал.

¹⁹ Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 17-р тал.

оруулах, зээлийн тусламжаар барьж байгуулсан зарим үйлдвэрийн газруудыг өр төлөх хэмжээнд акц гарган худалдах замаар хувь нийлсэн байгууллага болгож хувиргах, өрийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Орос Улсын эд хөрөнгө оршиж буй газрын түрээсийг төлбөрт тооцох, өрийг газрын хэвлий, ус, ой болон бусад нөөцийг Монголд Оросын байгууллага болон Монгол-Оросын хамтарсан үйлдвэрүүдийн ашигласны төлбөр тооцох, Монголын байгууллагуудаас Оросын байгууллагуудад үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг олгосон зээлийн төлбөрт тооцох, өрийн нэгэн хэсгийг Монголын талд хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах, Монголын талтай тохиролцооны үндсэн дээр өрийн нэгэн хэсгийг гурав дахь талд шилжүүлэх, чөлөөт хөрвөх валютаар үндсэн өр, хүүгийн төлбөрийг хийх, түүнчлэн Монголын экспортын барааг Орос Улсад нийлүүлэх, хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд урьд оршиж байсан үнийн гажуудал болон бусад эсрэг нөлөөлөлтэй хүчин зүйлийг харгалзан олгосон зээлийн хэсгийг хүчингүй болгох, хүү тооцохгүйгээр төлбөрийн зарим хэсгийг урт хугацаагаар хойшлуулах, дэлхийн практикт мөрдөж байгаа өрийг зохицуулах бусад боломж, чиглэлүүдийн дагуу өр төлбөрийг зохицуулах иж бүрэн шийдвэрлэх асуудлаар хэлэлцээ хийж, түүнийг зохицуулах механизм, хэлбэр, хугацааг

тодорхойлж, 1992 оны 9 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрууддаа санал оруулахыг эрх бүхий байгууллагуудад даалгахаар болжээ.²⁰ 1993 оны “Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”-нд “гарын үсэг зурахтай зэрэгцэн хоёр орны Ерөнхийлөгч нар хамтарсан мэдэгдэлд гарын үсэг зурсан. Түүнд “хуучин ЗСБНХУ, БНМАУ-д 30-40-өөд онд гэм буруугүй олон хүний амь насыг бүрэлгэн, хоёр орны ард түмэнд сэтгэл санааны болон эд материалын асар их хохирол учруулж, үй олноор нь хоморголон хэлмэгдүүлж байсанд хоёр улсын Ерөнхийлөгч нар гүнээ харамсаж байна... Үүний улмаас Монголын ард түмэн туйлын хүнд хохирол үзсэн бөгөөд ялангуяа сэхээтний давхарга онцгой зүдүүр эдэлж, санваартан нар нийгмийн нэг хэсгийнхээ хувьд хэрэг дээрээ устгагджээ. Монгол Улсын олон иргэн ЗСБНХУ-д хэлмэгдэн цаазлагдсан юм. Хэдий тийм боловч үүний хариуцлага өнөөгийн ОХУ-д холбогдолгүй”²¹ гэсэн албан ёсны хамтарсан мэдэгдэл гаргасан бөгөөд өр зохицуулах талаар ямар ч албан ёсны тохиролцоо байгаагүй байна. Чингэхдээ ОХУ хэлмэгдүүллийн хохирлыг барагдуулах буюу нөхөн төлбөр хийлгэх гэсэн Монголын талын бүхий л шаардлагаас зайлсхийх боломжтой болж байхад нөгөө талд нь нэхэмжлэгчийн хувьд ЗХУ-ын хууль ёсны залгамжлагч ОХУ-д шилжин ирсэн БНМАУ-ын өр Монгол Улсад хэвээр үлдсэн юм. Монгол Улсын Засгийн газрын

²⁰ Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 17, 18-р тал.

²¹ Монгол Улсын Ерөнхийлөгч, ОХУ-ын Ерөнхийлөгч нарын хамтарсан мэдэгдэл. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 29-р тал.

урилгаар ОХУ-ын Гадаад хэргийн сайд Е.М.Примаков 1996 оны 11-р сарын 13-14-нд Монгол Улсад айлчлах үеэр гарсан Монгол-Оросын хамтарсан албан мэдээнд: “Хоёр тал хуучин ЗХУ-аас олгосон улсын зээлээс үүдсэн Монголын өрийн асуудлыг тэрхүү өр үүссэн түүхэн нөхцөлийг харгалзан хоёр талын комиссын хүрээнд, 1995 оны 11-р сарын 29-нд Улаанбаатарт гарын үсэг зурсан баримт бичигт тулгуурлан авч үзэхээ нотлов” хэмээн дурдсан. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаярын 2003 оны зургаадугаар сарын 26-наас долоодугаар сарын 3-ны өдрүүдэд ОХУ-ын Засгийн газрын дарга М.М.Касьяновын урилгаар ОХУ-д хийсэн албан ёсны айлчлалын дүнгийн тухай албан мэдээнд: “Монгол Улсад хуучин ЗХУ-аас шилжих рублиэр олгосон зээлийн өрийн асуудлыг зохицуулах хэлэлцээний дүнг авч үзээд 2000 оны 11-р сард Монгол Улсад ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины хийсэн айлчлал болон 2002 оны 3-р сард засгийн газрын тэргүүнүүдийн түвшинд хийсэн хэлэлцээний үеэр тохирсон ерөнхий зарчмуудыг удирдлага болгон холбогдох Меморандумд гарын үсэг зурснаар²² өрийн асуудлыг шийдсэн. 2004 оны 1 дүгээр сарын 13-14—ний өдөр ОХУ-ын Гадаад хэргийн сайд И.С.Иванов Монгол Улсад айлчлах үеэр гарсан Монгол, Оросын хамтарсан мэдэгдэлд: «их өр»-ийн асуудлыг эцэслэн шийдвэрлэсэн нь хэлхээ холбоогоо

олон чиглэлээр идэвхжүүлэх, түүний дотор хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг сэргээх таатай бололцоог нээсэн алхам боллоо²³ гэж талууд үзсэн. Үүнээс гадна Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын 2010 оны 12-р сарын 13-16-ны өдрүүдэд ОХУ-д хийсэн айлчлалын үеэр “ОХУ-ын өмнө Монгол Улсын хүлээх санхүүгийн үүргийг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”²⁴-ээр 174,2 сая ам. долларын 97,8%-ийг тэглэж үлдсэн 3,8 сая ам.долларыг энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн дотор Монголын тал нэг удаагийн мөнгөн төлбөрөөр эргэн төлнө” гэжээ. Харин тус хэлэлцээр байгуулснаас хойш 6 жилийн дараа ОХУ-ын Төрийн дум 2016 оны 1-р сарын 27-нд “ОХУ-ын өмнө Монгол Улсын хүлээх санхүүгийн үүргийг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр” -ийг сайшаан соёрхсоныг 2016 оны 1-р сарын 31-нд баталснаар “Их өрийн үлдэгдлийг хоёрдугаар сард багтааж төлнө гэсний дагуу Монголын тал нэг удаагийн мөнгөн төлбөрөөр 3 сая 832 мянга 515 долларыг төлж, Орост ямар ч өр төлбөргүй болсон байна.

Төмөр зам.

Хоёр талын айлчлал, яриа хэлэлцээний үеэр төмөр замын эрх зүйн шинэчлэлийн асуудал яригдаад даруй гуч гаруй жил болж байна. 1949

²² Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 232-р тал.

²³ Монгол, Оросын хамтарсан мэдэгдэл. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 235-р тал.

²⁴ ОХУ-ын өмнө Монгол Улсын хүлээх санхүүгийн үүргийг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 97, 98-р тал

оны 6 дугаар сарын 6-нд “Улаанбаатар төмөр зам» гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээр”²⁵ нь өнөөдрийг хүртэл шинэчлэгдээгүй, хүчинтэй хэвээр явсаар байгаа нь олон талаараа УБТЗ-ыг үр ашигтай, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх бодлого явуулахад саад тотгор болж байгаа нь хэнд ч нууц биш юм. 1992 оны Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протоколд дурдсанаар Хувь нийлүүлсэн Улаанбаатар төмөр зам байгуулах тухай хэлэлцээр, энэ хувь нийлүүлсэн байгууллагын дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хамтарсан санал боловсруулах ажлыг 1992 онд багтаан дуусгаж, саналаа өөрсдийн Засгийн газрын холбогдох газруудад даалгасан²⁶ байна. 2006 оны “Москвацийн тунхаглал”-д “УБТЗ-ыг шинэчлэх, удирдлагын бүтцийг зохистой болгох, түүний үйл ажиллагааны гэрээ, эрхзүйн суурийг шинэчлэх, түүнчлэн тарифын зохицуулалтын арга хэмжээг оролцуулан Орос Улс, Хятад улсын хооронд Улаанбаатар төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн

тогтвортой өсөлтийг хангах асуудлыг боловсруулах шаардлагатайг Талууд хүлээн зөвшөөрөв”²⁷ гэжээ. 2008 оны 4-р сарын 10-13-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын ОХУ-д хийсэн айлчлалын үеэр гарсан Монгол-Оросын хамтарсан албан мэдээнд “УБТЗ” хувьцаат нийгэмлэгийн үйл ажиллагааны үр ашгийг харилцан тохиролцсон шинэчлэлийн хөтөлбөрийн үндсэн дээр дээшлүүлэх, “УБТЗ”-ын гэрээ, эрхзүйн үндэс суурийг шинэчлэх ажлыг түргэтгэх арга хэмжээ авахаар тохиролцсон”²⁸ байна. ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевын 2009 оны 8-р сарын 25-26-ны өдрүүдэд Монгол Улсад айлчлах үеэр “Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”-д “Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг далайцтай шинэчлэх, түүний дотор “УБТЗ” ХНН-ийг байгуулах тухай 1949 оны 6-р сарын 6-ны өдрийн Засгийн газар хоорондын хэлэлцээрийг зах зээлийн эдийн засгийн зарчмын дагуу шинэчлэн байгуулах нь хамгийн тулгамдсан зорилтын нэг гэж талууд онцолсон”²⁹. Улаанбаатар төмөр замын найдвартай ажиллагааг хангахын тулд Тус гэрээг Монгол Улсын хөгжлийн өнөөгийн цаг үеийн шаардлага, хууль эрх зүйн

²⁵ “Улаанбаатар төмөр зам” гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээр”. Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. 2-р боть. УБ. 1981. 191-р тал.

²⁶ Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 15-р тал.

²⁷ Москвацийн тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 32-р тал.

²⁸ Монгол-Оросын хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал.

²⁹ “Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал. 77,78-р тал.

нэр томьёо, утга агуулга, зах зээлийн нийгмийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх, ялангуяа нийгэмлэгийн эдлэх монопол эрх болон татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэй холбогдох заалтуудыг эргэж харах шаардлагатай байна. “УБТЗ” нийгэмлэгийн үйл ажиллагаа нь түүхэн үүргээ нэгэнт гүйцэтгэж дууссан, олон улсын хуучирсан гэрээгээр өнөөг хүртэл зохицуулагдаж, Монгол Улсын Үндсэн хууль болон Татварын хуулийг зөрчсөөр байгааг тус гэрээний нэг зүйлийг дурдахад хангалттай юм. Тухайлбал, БНМАУ-ын Засгийн газар ЗХУ-ын Засгийн газар хоорондын 1949 оны гэрээний 10 дүгээр зүйлд “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газар хувь нийлүүлсэн нийгэмлэгийг ба түүний салбар, контор, төлөөлөгчдийн газруудыг байгуулах ба бүртгэх явдалтай хамаарагдсан ямар нэгэн албан татваруудыг үл хураана. Түүнчлэн БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр одоо байгаа болон ирээдүйд бий болох ямар нэгэн албан татварыг үл ногдуулна”³⁰ гэж заасан байна. Монгол Улсад ашиггүй гэрээний энэ заалтын дагуу Монгол Улсын нутаг дэвсгэр дэх төсөвт ямар ч татвар төлдөггүй цорын ганц аж ахуйн нэгж юм. Хувь тэнцүү хувьцаа эзэмшдэг УБТЗ нийгэмлэгийн дээд удирдлагыг хувь нийлүүлэгч хоёр тал тэнцүү хуваарилан хэрэгжүүлдэг бүтэц, зохион байгуулалт нь шийдвэр гаргалтад сөргөөр нөлөөлдөг тул Монголын Засгийн газар УБТЗ ХНН-т тавих хяналтыг сайжруулах зорилгоор

өөрийн эзэмшлийн хувьцааг 51 хувьд хүргэх боломжийг эрэлхийлсээр ирсэн.

2006 оны “Москвагийн тунхаглал”-д “Хоёр орны хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хамтарсан хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг чухал ач холбогдолтойг тэмдэглэн УБТЗ-ыг шинэчлэх, удирдлагын бүтцийг зохистой болгох, түүний үйл ажиллагааны гэрээ, эрх зүйн суурийг шинэчлэх, түүнчлэн тарифын зохицуулалтын арга хэмжээг оролцуулан Орос Улс, Хятад улсын хооронд Улаанбаатар төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтийн тогтвортой өсөлтийг хангах асуудлыг боловсруулах шаардлагатайг талууд хүлээн зөвшөөрөв”³¹ гэжээ. 2008 оны 4-р сарын 10-13-ны өдрүүдэд Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярын ОХУ-д хийсэн айлчлалын үеэр “УБТЗ”-ын гэрээ, эрхзүйн үндэс суурийг шинэчлэх ажлыг түргэтгэх арга хэмжээ авахаар тохиролцсон³². 2009 оны “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”-д “Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг далайцтай шинэчлэх, түүний дотор “УБТЗ” ХНН-ийг байгуулах тухай 1949 оны 6-р сарын 5-ны өдрийн засгийн газар хоорондын хэлэлцээрийг зах зээлийн эдийн засгийн зарчмын дагуу шинэчлэн байгуулах нь хамгийн тулгамдсан зорилтын нэг” гэж талууд онцлон, “УБТЗ” ХНН-ийн дүрмийн санг 250 сая ам.доллараар нэмэгдүүлэх

³⁰ “Улаанбаатар төмөр зам” гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээр. Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. II. УБ. 1981. 198-р тал.

³¹ Москвагийн тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 32-р тал.

³² Монгол-Оросын хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал.

хоёр талын эрмэлзлийг нотлов³³ гэжээ. Түүнчлэн ОХУ-ын Засгийн газрын дарга В.В.Путины урилгаар Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд 2010 оны 12-р сарын 13-16-ны ОХУ-д хийсэн айлчлалын үеэр гарсан хоёр орны засгийн газрын тэргүүн нарын хэлэлцээний дүнгийн тухай хамтарсан албан мэдээнд: “УБТЗ” ХНН-ийн дүрмийн санг тэнцүү хэмжээгээр 250 сая ам.доллароор нэмэгдүүлэх асуудлыг зохицуулахаар тохиролцсон³⁴. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевын урилгаар 2011 оны 5-р сарын 31-ээс 6-р сарын 3-ны өдрүүдэд ОХУ-д айлчлах үеэр гарсан Монгол-Оросын хамтарсан мэдэгдэлд “Монголын төмөр замын дэд бүтцийг байгуулах, шинэчлэх, орос-монголын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийг санхүүгийн хувьд бэхжүүлэн шинэтгэх, улмаар орос-монголын төмөр замын салбарын хамтын ажиллагааг бүхэлд нь сайжруулах, түүний дотор Монголын баялгийн шинэ нөөцийг ашиглах, шинэ төмөр зам тавихтай холбоотой асуудлыг хамтарсан төслүүдийн хүрээнд нягт уялдаатай шийдвэрлэхийг зорьж байгаагаа мэдэгдэв”³⁵ гэжээ. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын мэдээнд “Улаанбаатар төмөр зам”-ыг

далайцтай шинэчлэхээр тохиролцож, үүний тулд хос төмөр зам барих, төмөр замыг цахилгаанжуулах ажлыг яаралтай эхлүүлэн, 2020 он гэхэд дуусгахаар тохиролцож, Монгол Улсын төмөр замын дамжин өнгөрүүлэх боломжийг бүрэн ашиглаж, ОХУ, БНХАУ-ын хооронд дамжин өнгөрүүлэх тээвэрлэлтийн хэмжээг дорвитой нэмэгдүүлэхэд шаардлагатай хэлэлцээрийг энэ ондоо багтаан байгуулах чиглэлээр ажиллах болов”³⁶ гэсэн байна. Монгол Улс 1998 оноос хойш ОХУ, БНХАУ-тай дамжин өнгөрөх тээврийн асуудлаар гурван талын ерөнхий хэлэлцээр байгуулахаар хэд хэдэн удаа яриа хэлэлцээр хийсэн боловч тодорхой үр дүнд хүрээгүй байв. Харин 2018 оны 6 дугаар сарын 8-нд “Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”³⁷ байгуулан ОХУ-аар дамжуулан гуравдагч зах зээлд гаргах тохиолдолд ОХУ-ын нутгаар дамжин тээвэрлэх төмөр замын тээвэрлэлтэд 25 жилийн турш тогтвортой тарифын хөнгөлөлт эдлэх болж байна. Ийнхүү арван жилийн дараа Орос өөрийн нутгаар транзитын хямд, тогтвортой үнээр тээврийн коридор нээв. Уг хэлэлцээрт “Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам”-

³³ Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 78-р тал.

³⁴ ОХУ, Монгол Улсын Засгийн газрын тэргүүн нарын хэлэлцээний дүнгийн тухай албан мэдээ. . Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 85-р тал.

³⁵ Монгол-Оросын хамтарсан мэдэгдэл. . Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 105-р тал.

³⁶ ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 124-р тал.

³⁷ Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 186-р тал.

ын Засгийн газар хоорондын 1949 оны 6-р сарын 6-ны өдрийн хэлэлцээр зөрчигдөх тохиолдолд Тал тус бүр энэхүү хэлэлцээрийн үйлчилгээг зогсоох эрхтэй”³⁸ гэсэн байна. Өргөн хүрээтэй хамтран ажиллах аливаа санал, санаачилга байвч Монголын тал асуудлыг ганцаарчлан шийдэх эрх мэдэл байдаггүйгээс гуравдагч орнуудын хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны саналыг хүлээн авах боломжгүйн дээр УБТЗ нь үйл ажиллагааныхаа орлогоос олсон ашгаа (дивиденд) Оросын талтай тэгш хуваадаг.

Хийн хоолой.

Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-ыг холбосон байгалийн хийн хоолойг транзитаар дамжуулах асуудал хорь гаруй жил яригдаж ирсэн. Эрчим хүчний томоохон төсөл болох хий дамжуулах хоолой барих асуудал ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путины 2000 оны 11-р сард Монгол Улсад хийсэн айлчлалын үр дүнгээр гаргасан “Улаанбаатарын тунхаглал”-д “XXI зуунд хандсан бүс нутгийн эрчим хүчний томоохон төслүүд болох хий, газрын тос дамжуулах хоолой, цахилгааны шугамыг барьж байгуулах нь ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна. Тэдгээр төслийг хэрэгжүүлэхэд эдийн засаг, газар зүйн хүчин зүйлсийг харгалзан Монгол Улс оролцохыг Оросын тал дэмжиж байна”³⁹ хэмээн анх удаа тусгасан байдаг. Энэ үеэс хойш Монгол-Оросын Засгийн газар хоорондын

худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны хуралдаанууд болон ОХУ-ын Ерөнхий сайд М.Касьяновын 2002 оны 3-р сард Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр ОХУ-аас Зүүн Хойд Азид байгалийн хий дамжуулах хоолойн байгууламжийн төлөвийн талаар санал солилцож байв. ОХУ-ын Ерөнхийлөгч Д.Медведев 2009 оны 8-р сард Монгол Улсад айлчлах үеэр хоёр орны хооронд байгуулсан стратегийн түншлэл хөгжүүлэх тунхаглалд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Монгол Улсын нутгаар байгалийн хий дамжуулах хоолой барих асуудлыг хамтран судалж боловсруулах тухай санал гаргасан байдаг. 2016 оны 4 дүгээр сарын 14-ны “Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-т “Бага хэмжээний шингэрүүлсэн байгалийн хий болон/эсвэл шингэрүүлсэн нүүрс-устөрөгчийн хийг ашиглан Монгол Улсыг хийжүүлэх салбарт хамтран ажиллах асуудлыг судална”⁴⁰ гэсэн байна. БНХАУ-ын Чиндао хотноо 2018 оны 6-р сард зохион байгуулагдсан “Шанхайн хамтын ажиллагааны байгууллага”-ын дээд хэмжээний уулзалтын үеэр гурван улсын төрийн тэргүүн нарын дөрөв дэх уулзалтаар Ерөнхийлөгч Х.Баттулга «Монголын талаас удаа дараа тавьж буй Орос, Хятадыг холбох байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх саналыг

³⁸ Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 188-р тал.

³⁹ Улаанбаатарын тунхаглал. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004. УБ. 2006, 161-р тал.

⁴⁰ Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр. Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 164, 165-р тал.

Орос, Хятадын талууд хүлээн авч, нааштай хандана гэж найдаж байна» хэмээн хүсэлтээ илэрхийлсний дараа 9-р сард Ерөнхийлөгч Х.Баттулга ОХУ-ын Владивосток хотноо Дорнын эдийн засгийн форумд оролцох үеэрээ ОХУ-аас БНХАУ руу татах хийн хоолойг Монгол Улс өөрийн нутгаар дамжуулан барих талаар хамтран ажиллахад бэлэн байгаа тухайгаа мэдэгдсэн. Оросын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад 2019 оны 9-р сарын 3-нд айлчлах үеэр хоёр улс иж бүрэн стратегийн түншлэлийн гэрээ байгуулсны дараа “Газпром” компанийн Удирдах зөвлөлийн дарга А.Миллертэй 9-р сарын 9-нд уулзахдаа Орос Улсаас Хятад улс руу Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан байгалийн хий нийлүүлэх боломжийг судлах талаар үүрэг өгснөөр хийн хоолойн асуудлаар улс төрийн шийдвэр гарч, тооцоо судалгааны ажил эхлүүлсэн. 2019 оны 12-р сарын 3-6-нд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх ОХУ-д айлчилж байгалийн хийн хоолойг Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулах тухай Санамж бичгийг байгуулсан. 2020 оны 8-р сарын 25-нд “Газпром” компанийн удирдах зөвлөлийн дарга Алексей Миллер, Монгол Улсын Ерөнхий сайд

У.Хүрэлсүхтэй хийн хоолой тавих техник эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) боловсруулах хамтарсан компани байгуулах санамж бичигт гарын үсэг зурж, 2021 оны 1-р сард “Газпром” компани хийн хоолойн Монголын нутгаар дамжин өнгөрөх хэсгийг “Союз Восток хийн хоолой” хэмээн нэрлэж, тус компанийг Монгол Улсад бүртгүүлж, уг хоолойн төсөл нь “Сибирийн хүч-1” хоолойноос 1,3 дахин их нэвтрүүлэх хүчин чадалтай буюу жилд 50 тэрбум шоо метр нийлүүлэхээр урьдчилсан байдлаар тооцоолсон байна.

Тус төсөл нь Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зэрэг Монгол Улсын эдийн засаг, байгаль орчинд ихээхэн эерэг нөлөөтэй байх боломжтой. Дээд түвшний уулзалт хэлэлцээрүүд ихээхэн ахицтай байж, Монгол Улс бэлтгэл ажлыг эхлүүлэхээр Газпром компанитай (ОХУ-ын ТӨҮГ) тохиролцсон билээ. Барилгын ажлыг 2023 онд эхлүүлэхээр төлөвлөсөн ч хориг арга хэмжээнд эрчим хүчний үйл ажиллагааг оруулбал Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлт ба цэвэр эрчим хүчний боломжийн чухал эх үүсвэр болох төсөл хойшлогдож болзошгүй байна.

Дүгнэлт

Сүүлийн гуч гаруй жилийн хугацаанд Монгол, Оросын өндөр дээд түвшний харилцан айлчлал, уулзалтуудын үр дүнд байгуулсан гэрээ, хэлэлцээрүүд нь хоёр орны харилцааны динамик, хэтийн төлөвийг тодорхойлох чухал баримт бичгүүд болохын хувьд 1990-ээд оны түүхэн шинэ нөхцөл байдалд зохицуулан эрх зүйн орчныг шинээр бүрдүүлэх шаардлага тулгарсан. Энэ үүднээс олон улсын харилцааны түгээмэл зарчмуудыг төлөвшүүлэх хамтын чин эрмэлзэл, хүчин чармайлтыг тусгасан, хоёр улсын харилцаа шинэчлэгдэн хөгжих эрх зүйн үндсийг тавьсан 1993 оны “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ” нь 2000 оны Улаанбаатарын тунхаглал, 2006 оны Москвагийн тунхаглал, 2009 оны Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал, 2019 оны Иж бүрэн стратегийн түншлэлийн тухай гэрээний үндсэн зарчим, суурь болж байдаг. Ийнхүү хоёр орны хууль, эрх зүйн орчин шинэчлэгдсэн хэдий ч ЗХУ-ын үеийн хоёр талын зарим гэрээ, хэлэлцээр өнөө хир хүчин төгөлдөр үйлчилсээр байгаа нь зарим асуудлууд эцэслэн шийдвэрлэгдэхэд саад учруулж байна. Тухайлбал, “БНМАУ-д тусламж үзүүлж буй

Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1971 оны протокол” болон “ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын нутаг дэвсгэрт газар олгох, барилга барих нөхцөлийн тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар хоорондын 1979 оны хэлэлцээр, “Улаанбаатар төмөр зам” гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан 1949 оны хэлэлцээрүүд өнөө хэр үйлчилсээр байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулах төдийхнөөр хязгаарлах бус, харин хөгжлийн өнөөгийн цаг үеийн шаардлага, хууль эрх зүйн нэр томьёо, утга агуулга, зах зээлийн нийгмийн нөхцөл байдалд нийцүүлэн шинэчлэх зайлшгүй шаардлагатай бөгөөд түүхэн үүргээ нэгэнт гүйцэтгэж дууссан, олон улсын хуучирсан гэрээгээр өнөөг хүртэл зохицуулагдсаар байгаад анхаарах нь зүйтэй юм.

Ном зүй

1. БНМАУ, ЗСБНХОУ-ын Найрамдал, сайн хөршийн хамтын ажиллагааны тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. , Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. 1991-2004 он. УБ. 2006. 5, 24-р тал.
2. “БНМАУ-д тусламж үзүүлж буй Зөвлөлтийн мэргэжилтнүүдийг байраар хангах, үйлчлэх зорилгоор БНМАУ-д орон сууц болон хэрэгцээт соёл, ахуйн объектуудыг барих тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ-ын Засгийн газар, ЗСБНХУ -ын Засгийн газар хоорондын 1971 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн протокол” болон ЗСБНХУ-аас БНМАУ-д нийлүүлж буй машин, тоног төхөөрөмж болон бусад эд ангийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэхэд зориулан зөвлөлтийн техникийн төвүүдийг байгуулахад зориулж БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХУ -ын Засгийн газар хоорондын 1979 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн хэлэлцээр”-г нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын ноот бичиг. Төрийн мэдээлэл. 2019.10.7. №38 /1091/, 1411-р тал.
3. Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 76-р тал.
4. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. , Монгол Улс, ОХУ-ын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ. 1991-2004 он. УБ. 2006. 25, 26-р тал.
5. Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 82-р тал.
6. Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Оросын цэргийн байрлах нь дуусгавар болж гарахтай холбогдсон эд хөрөнгийн болон санхүүгийн асуудлыг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр. <https://irkutsk.consul.mn/post/1346А.Нямдолжин>. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. УБ. 2022. 144-р тал.
7. Монгол Улс, ОХУ-ы, хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 78-р тал
8. Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 166-р тал
9. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан Тунхаглал. <https://mfa.gov.mn/65949>
10. Монгол Улсын Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгийн ОХУ-д хийсэн ажлын айлчлалын тухай протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-

- 2004 он. УБ. 2006. 10-р тал.
11. Монгол Улсын Ерөнхийлөгч, ОХУ-ын Ерөнхийлөгч нарын хамтарсан мэдэгдэл. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 29-р тал.
 12. Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д албан ёсоор айлчилсан дүнгийн тухай хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 232-р тал.
 13. Монгол, Оросын хамтарсан мэдэгдэл. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 235-р тал.
 14. Москвагийн тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 32-р тал.
 15. Монгол-Оросын хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал.
 16. “Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал. 77,78-р тал.
 17. Москвагийн тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 32-р тал.
 18. Монгол-Оросын хамтарсан албан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 59-р тал.
 19. Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 78-р тал.
 20. Монгол-Оросын хамтарсан мэдэгдэл. . Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 105-р тал.
 21. Монгол Улс, ОХУ-ын хооронд стратегийн түншлэл хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр. Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 164, 165-р тал.
 22. А.Нямдолжин. Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдалд ОХУ-ын гүйцэтгэх үүрэг. Олон улс судлал-2021: Монголын Орос судлал. УБ. 2022. 144-р тал.
 23. ОХУ-ын Засгийн газрын дарга В.В.Путины Монгол Улсад ажлын айлчлал хийсэн тухай хэвлэлийн хамтарсан мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 71-р тал.
 24. ОХУ-ын өмнө Монгол Улсын хүлээх санхүүгийн үүргийг зохицуулах тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн хоорондын хэлэлцээр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 97, 98-р тал Положение о статусе наблюдателя при Шанхайской организации сотрудничества. 16 июня 2004. <http://www.kremlin.ru/supplement/3917>
 25. ОХУ, Монгол Улсын Засгийн газрын тэргүүн нарын хэлэлцээний дүнгийн тухай албан мэдээ. . Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 85-р тал.
 26. ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины Монгол Улсад хийсэн ажлын айлчлалын

- мэдээ. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 124-р тал.
27. Соглашение между Правительством Союза Советских Социалистических Республик и Правительством Китайской Народной Республики о руководящих принципах взаимного сокращения вооруженных сил и укрепления доверия в военной области в районе советско-китайской границы. Москва. 24.04.1990. <https://base.garant.ru/2570276/>
 28. Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Монгол-Оросын харилцаа: Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 186-р тал.
 29. Төмөр замаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр. Баримт бичгүүд. 2005-2020. УБ.2020. 188-р тал.
 30. Удо Баркман. Орчин цагийн Монголын тухай өгүүллүүд. УБ.2008. 25-р тал.
 31. Улсын Дээд шүүхийн тогтоол. Дугаар 001/ХТ2023/0024. 2023 оны 04 сарын 03 өдөр. https://shuukh.mn/single_case/3045?daterange=2023/01/01%20-%202023/06/01%20&id=3&court_cat=3&bb=1
 32. “Улаанбаатар төмөр зам” гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээр”. Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. 2-р боть. УБ. 1981. 191-р тал.
 33. “Улаанбаатар төмөр зам” гэдэг Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн нийгэмлэг байгуулах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газруудын хооронд байгуулсан хэлэлцээр. Монгол-Зөвлөлтийн харилцаа. 1921-1974. II. УБ. 1981. 198-р тал.
 34. Улаанбаатарын тунхаглал. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004. УБ. 2006, 161-р тал.
 35. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 17-р тал.
 36. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 17, 18-р тал.
 37. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдааны протокол. Монгол-Оросын харилцаа баримт бичгүүд. 1991-2004 он. УБ. 2006. 15-р тал.

Analysis of some issues regarding treaties and agreements concluded between Mongolia And Russia

Nyamdoljin Adiya

Ph.D

*Institute of International Studies,
Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia
nyamdoljin@mas.ac.mn*

Abstract: *In this article, the author refers to the Agreement on Friendly Relations and Cooperation between Mongolia and the Russian Federation of 1993, the Ulaanbaatar Declaration of 2000, the Moscow Declaration of 2006, the Declaration on the Development of Strategic Partnership between Mongolia and the Russian Federation of 2009, and “Agreement between Mongolia and Russia on friendly relations and comprehensive strategic partnership” of 2019. Some current issues of relations between the two countries are analyzed by analyzing legal documents and other agreements.*

Key words: *agreements and negotiations, Mongolian-Russian relations, Russian real estate, heavy debts, railways*

<i>The day of submission:</i>	<i>2023.11.20</i>
<i>Completion of review:</i>	<i>2023.12.05</i>
<i>Final decision for acceptance:</i>	<i>2024.01.05</i>